ЦАХИМ ЖОР ОЛГОХ ЗААВАР

ЭНГИЙН ЖОРООР ОЛГОХ ЗААВАР





- 1) -р заасан талбарт жорын дугаараа оруулна.
- 2) -р заасан талбар иргэний регистерийн дугаарыг оруулна.
- 3) -р заасан Дуудах товчийг дарж жороо дуудна.
- 4) -р заасан талбарт жорын төлөв харагдана. Энд Идэвхитэй гээд ногоорсон байвал олгож болно.
- 5) -р заасан талбарт жорын ангилал харагдана. Голдуу Бусад хөнгөлөлтгүй энгийн жор гэж харагдана.
- -р заасан талбарт эмчийн бичсэн Олон улсын нэршил эсвэл худалдааны нэршил харагдана. Энгийн жор дээр үүнийг солих боломжгүй тул та зүгээр харж байгаад тохирох эмээ олгоно.
- 7) -р заасан талбарт эмчийн бичсэн тоо ширхэг харагдана.
- 8) -р заасан F4. Баркод талбарт та олгож буй эмийнхээ баркодыг уншуулна.

- 9) -р заасан F5. Эмийн нэр талбарт олгож буй эмийнхээ нэрийг бичээд сонгож болно.
- 10) -р заасан Тоо хэмжээ талбарт танайх өөрийн үлдэгдлээс хасагдах тоогоо оруулна.
 - а. Эмч үргэлж ширхэгээр бичдэг. Харин танайх тухайн эмийг ширхэгээр биш хайрцаг эсвэл трүпээр зардаг байж болно. Ийм үед жишээ нь эмч 30 -г бичсэн байхад танайх трүпээр зардаг бол 3 гэсэн тоо оруулах ёстой болно. Хэрэв хайрцгаар зардаг бол бүр 1 гэсэн тоо оруулж ч болно. Энд хэд гэж бичнэ, яг түүгээр танай үлдэгдэл хасагдана шүү.
- 11)-р заасан талбарт нийт үнэ харагдаж байна. Хөнгөлөлтгүй учир шууд танай зардаг үнээр бодогдоно.
- 12)-р заасан F2. Төлөх товчийг дараад борлуулалтаа гүйцээх буюу жор бичих үйлдэл маань дуусч байгаа юм. Үүнээс цааш таны мэддэг Төлбөр цонх гарч ирнэ. Цааш та яахаа мэднэ.

Анхаарах зүйлс:

 Хэрэв жор дахь 2 эмнээс нэгийг нь олгоогүй бол 9 -р заасан Эмийн нэр талбарыг хоосон орхиход л болно.

Дараагийн хуудсанд Хөнгөлөлттэй жороор олгох заавар бий ...

ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЖОРООР ОЛГОХ ЗААВАР



Орион програмын зүүн дээд хэсэгт байх "**F10. ЦАХИМ ЖОРООР ОЛГОХ**" товчийг дарна.

Дараах ЦАХИМ ЖОР БҮРТГЭХ цонх нээгдэнэ:

	ЦАХИМ ЖОР БҮРТГЭХ	2, 1,	/3	14	4 /5			<u>15</u> √	×
	Жорын дугаар (F10): Регистрийн дугаар:	393683 ЦА74112861 Д	уудах Ангилал: Хөн	эвхитэй нгөлөлттэй жор	Даатгуул Даатгуу	агчийн овог: лагчийн нэр:	БАТТОГТОХ ТУЯА	Утаснь 990436	69
	Онош:	341 Энгийн ба салсархаг-идз пневмони;	эт бронхит;J12 Өөр бүлэгт ангилаагүй вирүст •		Бүрт Хүчин	Бүртгэсэн огноо: Хүчинтэй хугацаа:		2024-11-28 04:34:24 2024-12-05 16:34:24	
	Эмнэлгийн нэр: Эмнэлгийн хаяг:	Өрнөх эрүүл жаргал өрхийн УЛААНБААТАР	эрүүл мэндийн төв / Баянз 7 8	γpx / 9 \	Хэв	лэсэн огноо: мчийн шифр:	2024-11-28 04:3 71101361	4:24	
-	Эмийн олон улсын нэр Нэмэлт т	МЧИЙН БИЧСЭН ЭМ эмдэглэл Худалдааны н	эр <u>тоо</u> F4.	Баркод Б	БОРЛ F5. Эмийн нэр	УУЛСАН ЭМ Тоо хэмжээ	Нийт үнэ	Нийт даатгал	Нийт авах дүн
l	 КЛАРИТРОМИЦИН 341; 1*2 ОСЕЛЬТАМИВИР 312; 1*2 	КЛАРИТРОМИЦИН, Худалдааны нэр	5. 💽 10 89(178)	3003221 Клари Дээд үнэ	тромицин 500мгп Даатгал		20,000 37,500	10,000 26,2 5 0	10,000
	КЛАРЕМ 500, 500 МІ КЛАРИ-БКРС, 500 М КЛАРИТРОМИЦИН, КЛАРИТРОМИЦИН, КЛАРИТРОМИЦИН		IГ ИГ 500 МГ ПРОТЕХ-500, 500 МГ		1,870 935 1,700 850 2,000 1,000 1,800 900 2,000 1,000		10 57,500	11 36,250	21,250
	Энэ даатгуулагч энэ жор дээрхи эмүүдийг сүүлд авсан байдал	Эмийн о CLARITHRC OSELTAMIVIK	יי אר סיאאח היעזי	2027-11-20 10:43	2,000 1,000 2,490 1,245 2,500 1,250	+э 24,900 37,500	Нийт даатгал 12,45 26,25	Нийт авса 0	ан дүн 12/450 11,250
	Нэхэмжлэх дүн шалгах Нэгтгэл тайлан гаргах	 Заавар Видео нээх Очсон жор шалгах 	Даатгуулагчийн Э Өмнөх Жоруудыг Харах	ЭМД жагсаалт	Өөрөө ирл ЧА861027	к авсан 06	14 F2: T0 Ward	13 элөх	Гарах 2024-06-17

Зурагт улаан тоогоор заасан талбаруудын тайлбар:

- 1) -р заасан талбарт жорын дугаараа оруулна.
- 2) -р заасан талбар иргэний регистерийн дугаарыг оруулна.
- 3) -р заасан Дуудах товчийг дарж жороо дуудна.
- 4) -р заасан талбарт жорын төлөв харагдана. Энд Идэвхитэй гээд ногоорсон байвал олгож болно.
- 5) -р заасан талбарт жорын ангилал харагдана. Хөнгөлөлттэй жор биш өөр үг байвал хөнгөлөлтгүй жор гэсэн үг. Гэхдээ төлөв нь Идэвхитэй бол олгож болно. Энэ тухай энэ зааврын "Энгийн жороор олгох заавар" сэдвээс харж болно.
- 6) -р заасан талбарт эмчийн бичсэн Худалдааны нэршил харагдана. Арын сум дээр нь дараад яг аль нэршлээр олгохоо сонгоно. Энд ямар нэршил сонгосноос хамаарч эмийн үнэ, хөнгөлөх хэмжээ өөрчлөгдөх тул үүнийг Заавал сонгож байх ёстойг анхаарна уу.

- 7) -р заасан талбарт эмчийн бичсэн тоо ширхэг харагдаж байна. Хааяа иргэн бичүүлснээсээ цөөн тоогоор авч болдог. Ийм үед энэ тоон дээр очоод шууд бууруулж бичиж болно. Энэ үед арын нийт үнэ, нийт хөнгөлөлт, иргэнээс авах дүнгүүд дагаж өөрчлөгдөнө.
- 8) -р заасан F4. Баркод талбарт та олгож буй эмийнхээ баркодыг уншуулна.
- 9) -р заасан F5. Эмийн нэр талбарт олгож буй эмийнхээ нэрийг бичээд сонгож болно.
- 10) -р заасан Тоо хэмжээ талбарт танайх өөрийн үлдэгдлээс хасагдах тоогоо оруулна. Энд тоо хэмжээтэй хоёр талбар байгааг анхаарна уу. Эхнийх нь 7 -р заасан эмчийн бичсэн тоо, дараагийнх нь энэхүү 10 -р заасан танай өөрийн тоо юм.
 - а. Эмийн нэр сонгох үед энд автоматаар тоо ороод ирдэг. Энэ тоог заавал шалгаж, засах хэрэгтэй бол шууд засаж байх ёстойг хатуу анхаарна уу. Учир нь эмч үргэлж ширхэгээр бичдэг. Харин танайх тухайн эмийг ширхэгээр биш хайрцаг эсвэл трүпээр зардаг байж болно. Ийм үед жишээ нь эмч 30 -г бичсэн байхад танайх трүпээр зардаг бол 3 гэсэн тоо оруулах ёстой болно. Хэрэв хайрцгаар зардаг бол бүр 1 гэсэн тоо оруулж ч болно. Энд хэд гэж бичнэ, яг түүгээр танай үлдэгдэл хасагдана шүү.
- 11)-р заасан талбарт Нийт үнэ харагдаж байна. Энэ нь жагсаалтын дээд үнээр бодсон дүн юм. Заримдаа та эмийг дээд үнээс нь хямдаар олгож болно. Тийм үед энд шууд нийт үнээ бууруулж бичиж болно. Энэ үед иргэнээс авах дүн дагаад буурна.
- 12) -р заасан талбарт Нийт даатгал харагдаж байна.
- 13)-р заасан талбарт иргэнээс Авах дүн харагдаж байна.
- 14)-р заасан F2. Төлөх товчийг дараад борлуулалтаа гүйцээх буюу жор бичих үйлдэл маань дуусч байгаа юм. Үүнээс цааш таны мэддэг Төлбөр цонх гарч ирнэ. Цааш та яахаа мэднэ.
- 15)-р заасан талбарт иргэний утасны дугаарыг оруулж болно. Тэгвэл дараа нь борлуулалтаас утасны дугаарыг нь харж болно

Анхаарах зүйлс:

- 6 -р заасан эмчийн бичсэн Худалдааны нэршлийн арын суман дээр дараад яг аль эмийг олгож байгаагаа заавал сонгож байх ёстой. Үүнийг хүмүүс мартаад байдаг. Энд сонголт хийлгүй орхивол буруу эмээр жор бичигдэхийг хатуу анхаарна уу.
- 10 -р заасан Тоо хэмжээ нь танай үлдэгдлээс хасагдах тоо гэдгийг анхаарна уу. Энэ тоо өөрөө бөглөгддөг ч тэр нь зөв байх албагүй шүү. Тиймээс үүнийг заавал шалгаад, засах ёстой бол засаж байна уу. Мөн танайх ширхэгээр зардгүй эм бол зардаг нэгжрүүгээ хөрвүүлсэн тоо оруулах ёстой. Жишээ нь эмч 30 -г бичсэн үед танайх трүпээр зардаг бол 3 гэсэн тоо оруулна, г.м.
- Хэрэв жор дахь 2 эмнээс нэгийг нь олгоогүй бол 9 -р заасан Эмийн нэр талбарыг хоосон орхиход л болно.